



## БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 232

Улаанбаатар хот

Барилгын тусгай зөвшөөрлийг шинээр олгох,  
нэмэлт ажлын төрлөөр олгох, сунгах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 15 дугаар зүйлийн 15.14.3, 15.14.6, Барилгын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 20 дугаар зүйлийн 20.3, 20.5, 20.6, 33 дугаар зүйлийн 33.1.15-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ-ын 2021 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн 21/732/ТЗ тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт”-ыг нэгдүгээр, “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг нэмэлт ажлын төрлөөр олгох байгууллагын жагсаалт”-ыг хоёрдугаар, “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг сунгах аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт”-ыг гуравдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Барилгын тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Гантулга/-т, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллахыг “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ /Д.Цэрэнжигмэд/-д тус тус даалгасугай.

Б.МӨНХБААТАР

151010713

Барилга, хот байгуулалтын сайдын  
2021 оны 11 дугаар сарын 01-ны өдрийн  
11 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН  
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ШИНЭЭР ОЛГОХ АЖ  
АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ**


№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Барилгын ажлын төрөл	Хугацаа
1	“Амжилтын хөтөч” ХХК	Зураг төсөл, шинэ ЗТ-3.7	5
2	“Билэгт хос ертөнц констракшн” ХХК	Барилга угсралт, шинэ БА-7.1	5

Барилга, хот байгуулалтын сайдын  
2021 оны 11 дугаар сарын 01-ны өдрийн  
11 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН  
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ НЭМЭЛТ АЖЛЫН ТӨРЛӨӨР  
ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Барилгын ажлын төрөл	Хугацаа
1	"Саруулшилтгээн констракшн" ХХК	Барилга угсралт, нэмэлт БА-3.1	-
	"Төгс энгүүн" ХХК	Барилга угсралт, нэмэлт БА-2.1, 2.2	-

Барилга, хот байгуулалтын сайдын  
2021 оны 11 дугаар сарын 01-ны өдрийн  
дугаар тушаалын гуравдугаар хавсралт



**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН  
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ АЖ АХУЙН  
НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Барилгын ажлын төрөл	Хугацаа
1	"Нойкрафт ХХК	Барилга угсралт, сунгалт БА-2.1, 3.4, 3.5, 6.1, 6.2, 6.3, 6.4	5
2	"Мөнхтооройт" ХХК	Барилга угсралт, сунгалт БА-2.1, 2.2, 3.1, 3.3	5